

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Д/Д	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги төлөвлөгөө /2020-2024/, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 2. Эрдэс баялгийн салбарын (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги) салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах.								
Зорилт 4. “Эрдэс баялгийн салбарын (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги) хэмжээнд мөрдөх дүрэм, журам, ангилал, заавар, шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах”-ЫН ХҮРЭЭНД								
1.	2.4.2	Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам,		Боловсруулсан төслийн тоо	0	2	7 1. “Сонгон шалгаруулалтын журам”-ын төслийг боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын	100

		заавар, норм, норм норматив, стандарт, аргачлал, маягтыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах.	Улсын төсөв			2024.12.27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулан, ХЗДХЯ-нд хүргүүлж 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 7084 дугаарт бүртгүүлсэн. 2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/47 дугаар “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулав. 3. “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журам”-ыг шинэчлэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/19 дүгээр тушаалын хавсралтаар батлуулсан. 4. “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/06, А/04 дүгээр хамтарсан тушаалаар батлуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7131 дугаарт бүртгүүлсэн. 5. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. 6. Үүсмэл (Техноген) ордын болон Дагалдах ашигт малтмалын аргачилсан зөвлөмжийг ЭБМЗ-ийн 2025.02.04-ний өдрийн ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, АҮЭБ-ийн сайдын 2025.03.07-ний өдрийн А/47 дугаар тушаалаар хүлээн авсан. Нийт 32 төрлийн ашигт малтмалаар аргачилсан зөвлөмж боловсруулагдаж дууссан. 7. “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08”-ын үндэсний индекс/код бүхий ажил, мэргэжилд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Монголын Геологийн Холбоодын Нэгдсэн Зөвлөлтэй хамтарч “Геологийн салбарын ажил, мэргэжил”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал /Ажил, мэргэжлийн профайл гаргах геологийн салбарын индекс/код бүхий... ажил мэргэжлийн жагсаалт, профайл/-ыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын	
--	--	--	----------------	--	--	---	--

							яамд хүргүүлсэн. ГБХНХСайдын тушаал 2025.03.31-ний өдрийн А/79 дүгээр тушаал батлагдсан.	
Зорилт 5. “Эрдэс баялгийн салбарын (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги) хэрэгжүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэгдсэн удирдлага, бодлого, төлөвлөлтөөр хангах”-ЫН ХҮРЭЭНД								
2.	2.5.1	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлуулах ажилд оролцох.	Улсын төсөв	Хуулийн хугаанд боловсруулж хүргүүлсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1 Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлуулах ажилд оролцсон.	100
Зорилго 6. Эрдэс баялгийн салбарт (геологи, цөмийн энерги, уул уурхай, газрын тос)-ын салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах.								
Зорилт 1. ЗГҮАХ-ийн 3.3.1.2 д “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ” -ЫН ХҮРЭЭНД								
3.	6.1.1	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологийн судалгааны ажлын төслийн хээрийн судалгааны ажил, тайлан боловсруулалтын ажлын хяналт хийх.	Улсын төсөв	Төслийн тоо	0	4-5	1.2025 онд шинээр зарлагдсан 1:50000-ны мс-тай ГЗЕЭА-ын 9-н төсөл, сэдэвчилсэн судалгааны 7-н төслийн ажлын геологийн даалгаврын төсөл боловсруулахад оролцсон. Геологийн даалгавар батлагдаж, 16 төслийн тендер зарлагдсан. Төслийн тоо 16 2.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Эрдэнэцагаан-50, Агаарын геофизик-2024, Структур гидрогеологи-2025 төслүүдийн хээрийн ажилд хяналт хийсэн. Төслийн тоо 3	100

4.	6.1.3	Монгол орны газар зүйн нэрийн салбар зөвлөлтэй хамтран ажиллаж, санал хүргүүлэх.	Улсын төсөв	Санал хүргүүлсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1 Монгол Улсын Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2025 оны А/337 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол орны Газар зүйн нэрийн зөвлөлд гишүүнээр томилогдон ажиллаж байна. Газар зүйн нэрийн зөвлөлийн 2025 оны ээлжит хурлууд дараах хугацаанд зохион байгуулагдсан. Үүнд: • 01-р хурал – 2025.04.01; • 02-р хурал – 2025.06.20; • 03-р хурал – 2025.09.29; • 04-р хурал – 2025.11.25. Дээрх хуралд АҮЭБЯ-ыг төлөөлөн оролцож, хэлэлцэж буй асуудлуудад саналаа илэрхийлэн, шийдвэр гаргахад оролцсон.	100
Зорилт2.” Улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, ашигт малтмалын хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, уул уурхайн тогтвортой хөгжлийг хангуулах чиглэлээр бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах” -ЫН ХҮРЭЭНД								
5.	6.2.1	Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хүлээн авах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, төрөл бүрийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах хэрэгжилтэд хяналт тавих.	Улсын төсөв	Нөөц бүртгэгдсэн ордын тоо	3135	3200	3233 ЭБМЗ-ийн Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 18 удаагийн хурал, өргөтгөсөн 2 удаагийн хурал зохион байгуулж оролцсон. Хурлаар хайгуулын ажлын үр дүнгийн 141 тайланг хэлэлцүүлэх хүсэлт ирүүлснээс 132 тайланг хэлэлцэж, шийдвэр гарсан 98 тайлан. ЭБМЗ-ийн хурлын дүгнэлт-98, тэмдэглэл-98 хянаж, баталгаажуулсан. Үр дүнгийн тайланд 138 тайланд шинжээч томилсон.	100
6.	6.2.2	Ашигт малтмалын ордын нөөцийн бүртгэл, хөдөлгөөн, тэнцэл хийх хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулах, цахимжуулах, Ашигт малтмалын төрлөөр нөөцийн тэнцлийг гаргаж, нөөцийн болон ордын шаардлагатай мэдээллийг гаргах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Ашигт малтмалын төрлөөр	0	8	Үндэсний Геологийн Албанд Ашигт малтмалын 8-н төрлөөр нөөцийн тэнцэл гаргах ажил хийгдэж байна. УГА-ны мэргэжилтний орон тоо багатай, ажлын ачаалал ихтэй байгаатай холбоотой ажил удаашрилтай явагдаж байна. ,	70

Зорилт 3. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах”-ЫН ХҮРЭЭНД								
7.	6.3.1	Стратегийн ач холбогдолтой ордод хамаарах ордуудын талбайн хил заагийг тогтоож, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Батлуулсан эрх зүйн актын тоо	8	14	16 орд Стратегийн ач холбогдол бүхий Асгатын мөнгөний орд, Төмөртэйн овоогийн цайрын орд, Дорнодын ураны орд, Мардайн ураны орд, Гурванбулагийн ураны орд, Оюутолгойн бүлэг орд, Бороогийн алтны үндсэн орд, Төмөртэй төмрийн хүдрийн 8 ордын талбайн хил, заагийг тогтоон ЗГ-ын тогтоолын төсөл, тэмдэглэл, яамдаас авсан саналын нэгтгэлийг бэлтгэж 2025.04.01-ний 01/950 тоотой ЗГХЭГ-т хүргүүлэн ЗГ-ын 2025.04.08, 04.09-ний өдрүүдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 170 дугаар тогтоолоор тогтоосон. Стратегийн 16-н ордын хил заагийг тогтоож дууссан.	100
8.	6.3.2.	Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хавсралт 2-д заасан 39 ордыг стратегийн ордод хамааруулах эсэх талаар ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд санал боловсруулах, зохион байгуулах.	Улсын төсөв	Санал хүргүүлсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	1	1	1 Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хавсралт 2-д заасан 39 ордыг стратегийн ордод хамааруулах эсэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах саналыг боловсруулж Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад даалгаж, Засгийн газрын 2025 оны 16 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд заасны дагуу Сангийн сайдтай хамтран ордын үнэлгээг тогтоох, стратегийн ордод хамруулах эсэх саналыг бэлтгэн Засгийн газрын хуралдаан санал бэлтгэж оруулахаар ажиллаж байна.	100
Зорилт 4. ЗГҮАХ-ийн 3.3.1.4 “Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.”-ЫН ХҮРЭЭНД								
9.	6.4.1	Цагаансуваргын зэс молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Бүтээн байгуулалтын ажил, хувиар	0	10	 “Эрдэнэс цагаан суварга” ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын ордод үйл ажиллагаа явуулах ил уурхайг ашиглалтад хүлээлгэн өгөх тухай хүсэлтийг тус яаманд ирүүлсэн. Хүсэлтийн дагуу холбогдох бичиг баримтын бүрдэлтэй танилцаж, хянан дутуу баримтыг гүйцээсний	100

							дараа Улсын комисс ажиллахаар шийдвэрлэн тус компанид мэргэжил аргазүйн зөвлөмж ажиллаж байна.	
Зорилт 5. ЗГҮАХ-ийн 3.3.1.10 “Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина.”-ЫН ХҮРЭЭНД								
10	6.5.1	Алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Ашиглалтад оруулсан эсэх, тоогоор	0	1	1 1.“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшиж байгаа Баянхонгор аймгийн Шинэжинст суманд байрлах MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баянхөндий төсөл”-ийн алтны үндсэн ордын ил уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, тус ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн ЭБМЗ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. Улсын комисс 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ажиллаж, уурхай болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан. 2.2025 оын 10 дугаар сард Төв аймгийн Борнуур сумын нутагт орших Харганы алтны үндсэн ордын далд уурхайг ашиглалтад өгөхөөр “Гүнбилэг гоулд” ХХК, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Улаанчулуутын алтны үндсэн ордын уурхайг ашиглалтад өгөх “Мандговь” ХХК-ийн хүсэлтийн дагуу Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Улсын комисс тус уурхайнуудад ажиллаж, холбогдох шийдвэрийг гарган, үйл ажиллагааг нь эхлүүлэх боломжийг бүрдүүлсэн.	100
11	6.5.2	“Алт-3” аяныг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Зохион байгуулсан эсэх (Тийм: 1, Үгүй: 0)	1	1	1 “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025.07.09-ны 85 дугаар тогтоолыг батлуулсан. Мөн түүнчлэн 2025 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлсэн бөгөөд уг тогтоолд алтны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олборлолтод бэлтгэсэн зарим ордыг тусгай хамгаалалттай газар нутгаас гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулахаар холбогдох заалтуудыг	100

							тусгасан. Улмаар 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, баталсан. Гэвч уг тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хэсэгчилсэн хориг тавьж, олборлолтод бэлтгэсэн зарим ордыг тусгай хамгаалалттай газар нутгаас гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал хасагдсан. Их хурлын тогтоол болон Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/169 дугаар тушаалаах “Ажлын төлөвлөгөө”-г баталсан. Төлөвлөгөөнд туссаны дагуу "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хил заагт өөрчлөлт оруулж, нөөц нь тогтоогдсон алтны тусгай зөвшөөрлийг ашиглах боломжтой эсэхийг судлах" мөн "Алтны хэтийн төлөв бүхий ашиглалтад өртөж нөхөн сэргээлт хийгдээгүй газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талаар судлах" үүрэг бүхий Ажлын хэсгүүдийг байгуулахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Одоогоор БОУАӨЯ-ны төлөөллүүд тодорхой болоогүйгээс Ажлын хэсгүүдийн тушаал албажаагүй хүлээгдэж байна. -Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 211 дүгээр тогтоолын дагуу тус яамнаас хөрөнгө оруулалт шаардлагатай, хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй алт олборлогч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, судалгаа авч урьдчилсан тооцоолол хийн 2025.09.18-ны өдрийн 01/2708 дугаар албан бичгээр СЯ, ЭЗХЯ, Монголбанканд хүргүүлсэн. - 2025 оны 12 дугаар сарын байдлаар алтны 13 төслийн ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж шийдвэрлээд байна.	
Зорилт 6. “ЗГҮАХ-ийн 1.3.2.2 “Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож эргэлтэд оруулна.”-ЫН ХҮРЭЭНД								
12	6.6.1	Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө, нэмэлт хайгуулын ажил, хагас	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Хайгуул хийж үр дүнгийн тайлан боловсруултын хувь,	0	10	Асгатын мөнгөний ордын хайгуулын ажлын төлөвлөгөө батлагдан 2025 онд хайгуулын ажил хийгдсэн. “Эрдэнэс Монгол” ХХК 2025 онд зураглал, баганат өрөмдлөг, суваг малталт, налуу далд малталт, технологийн дээжлэлт, бусад дагалдах дээжлэлт, геофизикийн боловсруулалтын ажил хийсэн. Хээрийн ажлын үр дүнгээр суурин боловсруулалт хийгдэж байна. ОХУ-аас	100

		үйлдвэрлэлийн технологийн дээжлэлт, туршилт хийж үр дүнгийн тайлан боловсруулж, батлуулах.					хил нэвтэрч ажиллах зөвшөөрөл олгоогүйтэй холбоотой зарим ажлууд дутуу хийгдсэн. Эдгээр ажлуудыг 2026 онд хийхээр төлөвлөсөн байна.	
Зорилт 7. “Уурхай, уулын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж хүлээн авах, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлын зохион байгуулах”-ЫН ХҮРЭЭНД								
13	6.7.1	Ашигт малтмалын орд, баяжуулах үйлдвэрийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах, хянах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, төрөл бүрийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах хэрэгжилтэд хяналт тавих.	Хувийн хөрөнгө оруулалт	Зохион байгуулсан Эсэх (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1 Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар стратегийн 5-н ордын ТЭЗҮ, Ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 21 удаагийн хуралдаанаар 211 төслийн ТЭЗҮ-ийг хэлэлцэж шийдвэрлэсэн.	100
14	6.7.2	Ашиглалтад бэлтгэсэн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах ажлыг зохион байгуулах.	Хувийн хөрөнгө оруулалт	Хүлээн авсан уурхай, баяжуулах үйлдвэрийн тоо	400	420	437 Тус яаманд Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын дагуу уурхай, баяжуулах үйлдвэр ашиглалтад оруулахаар Улсын комисс ажилуулах тухай нийт 51 хүсэлтийг аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлснээс Улсын комисс 2025 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 37 уурхай, баяжуулах үйлдвэрт ажиллаж, холбогдох шийдвэрийг гарган албажуулсан.	100
15	6.7.3	Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэгтгэн хэрэгжилтийг хангуулах.	Улсын төсөв	Холбогдох мэдээллийг нэгтгэх	0	1	1 Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэгтгэн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.	100
Зорилт 8. “Тэсрэх материалын агуулах, тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, тэсрэх материал, тэсэлгээний хэрэгслийг импортлох, тэсэлгээний ажил үйлчилгээ явуулах, тэсэлгээний эрх олгох, сунгах үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах” -ЫН ХҮРЭЭНД								

16	6.8.1	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүйн бүсийг тооцоогоор тогтоох, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах.	Хувийн хөрөнгө оруулалт	Аюулгүйн бүс тогтоосон актын тоо	300	310	1.Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн 1 үйлдвэр, 2 агуулахын аюулгүйн бүсийг тооцоогоор тогтоож, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулсан. 2.2025 оны 09-өөс 12 дугаар сарын хооронд тэсрэх материалын үйлдвэр болон агуулахыг байнгын ашиглалтад хүлээн авах Ажлын хэсэг нийт 3 удаа 5 тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах, 2 тэсэлгээний цооног цэнэглэх төхөөрөмжид дүгнэлт гаргасан байна.	100
17	6.8.2	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.	Хувийн хөрөнгө оруулалт	Олгосон, сунгасан тусгай зөвшөөрлийн тоо	110	120	141 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг 5 удаагийн хурлаар тусгай зөвшөөрөл шинээр олгох болон шинэчлэн олгох 37 асуудал, 10 тэсрэх бодисын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж шийдвэрлэсэн.	100
18	6.8.3	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах, холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох.	Улсын төсөв	Боловсруулсан актын тоо	1	1	2 -Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. -"Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг шинэчлэн 2025 оны Засгийн газрын 264 дүгээр тогтоолын хавсралтаар батлуулсан.	100
Зорилго 8: Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.								
19	8.1	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэх.	Улсын төсөв	Шуурхай шийдвэрлэсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг 6 удаагийн хурлаар тусгай зөвшөөрөл шинээр олгох болон шинэчлэн олгох 31 асуудлыг шийдвэрлэсэн.	100

20	8.4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн боловсруулж, хууль эрх зүйн актанд бүртгүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар сонгон шалгаруулалтыг бусад Төрийн болон Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хамтран зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх.	Улсын төсөв	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	26	106	88 тусгай зөвшөөрөл -Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар “Сонгон шалгаруулалтын журам”-ыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 7084 дугаартай бүртгүүлсэн. - “Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/33 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. -Журам батлагдсантай холбоотой сонгон шалгаруулалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн. Нийт 88 хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож улсын төсөвт 94 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. -ҮГА-аар сонгон шалгаруулалтын материалыг бэлтгүүлэн ирүүлсэн материалтай танилцан зарлах талбайн жагсаалтыг АМГТГ-т хүргүүлэх ажилд хяналт тавьж ажилласан /талбай-263/.	100
21	8.6	Дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх.	Улсын төсөв	Батлуулсан эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-д заасныг хэрэгжүүлж, 2025 онд нийт Засгийн газрын 8 тогтоолоор 8 аймагт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зөвшөөрөл олгуулсан. 1. Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто зам /Хэнтий, Жаргалтхаан, Дэлгэрхаан сум/-ын 1-р хэсгийн 27.42 км авто замын бүтээн байгуулалтын барилгын ажил төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.06.25-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2. Хэнтий аймгийн нутаг дахь Хэрлэн голын 265 у/м төмөр бетон гүүр, Хэрлэн сумын нутаг дахь 14.2 км хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын барилгын ажил төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.03.12-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн.	100

						ЗГ Тогтоол #128 3. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх 43.3 км хатуу хучилттай авто зам (Өвөрхангай, Хужирт сум)-ын Багц-1 буюу 21.42 км авто зам төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.06.04-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #283 4. “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өртгөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/”, XVI.1.1.24 дүгээр зүйл “Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м гэрэлтүүлэг /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/”, XVI.1.1.40 дүгээр зүйл “Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/” төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.05.21-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #253 5. “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл” чиглэлийн хатуу хучилттай авто замын 4 дүгээр хэсгийн 23.13 км хатуу хучилттай авто зам” төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.05.28-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #274 6. “Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших “Хашаатын цав” нүүрсний уурхайгаас Хавиргын боомт хүртэлх 96.4 км тусгай зориулалтын авто зам” төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.08.06-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #39 7. “Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр сум хүртэлх хатуу хучилттай авто зам” төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай”	
--	--	--	--	--	--	--	--

							тогтоолын төслийг Засгийн газрын 2025.08.13-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #45 8. “Сэлэнгэ аймгийн Хушаат сумыг улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто зам” төслийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах, талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” тогтоолын төслийг Засгийн газрын 2025.08.13-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ Тогтоол #46	
22	8.7	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон асуудлаар нөхөх олговрын /дүйцүүлэх/ мэдээлэл бэлтгэх, нөхөн олговроор талбай дүйцүүлэн олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газарт хүргүүлэх.	Улсын төсөв	Хүргүүлсэн эсэх (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1 Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны А/62 дугаар тушаал, 2024 оны А/98 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг “Нөхөн олговроор дүйцүүлэн талбай олгох” мэдээллээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөх Л.Чой-Иш, Салбарын хяналтын газрын Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал болон яамны бүрэлдэхүүнд танилцуулга хийлгэсэн. Ажлын хэсгээс Засгийн газарт уламжлуулан шийдвэрлүүлэхээр 12 аж ахуйн нэгжийн 15 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нөхөх олговорт шинээр олгох 30 талбайн солбицол батлах асуудлыг ирүүлсэн. Үүний дагуу Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/969 дүгээр албан бичгээр санал авсан. Яамдын санал, давхцалыг хянан үзэж Ажлын хэсгээс дээрх Засгийн газрын тогтоолын төсөлд хамрагдсан 12 аж ахуйн нэгжийн 15 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нөхөх олговорт шинээр олгох 30 талбайгаас давхцалтай талбайг сольж хуулийн шаардлага хангуулан, аж ахуйн нэгжүүдтэй хэлэлцэн тохиролцож баталгаажуулан Засгийн газарт уламжлуулан шийдвэрлүүлэхээр дахин ирүүлсэн. Үүний дагуу "Нөхөх олговрын зориулалтаар тусгай зөвшөөрөл шинээр олгох талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай" Засгийн газрын тогтоолын төслийн хавсралтад өөрчлөлт оруулан дахин санал авахаар	100

							2025.05.23-ны өдрийн 01/1596 дугаар албан бичгээр хүргүүлж саналыг авч нэгтгэсэн.	
Зорилт 9. “Бичил уурхайн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах.”-ЫН ХҮРЭЭНД								
23	9.1	Бичил уурхайн чиглэлээр холбогдох тооцоо судалгаа хийх, санал боловсруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.	Улсын төсөв	Санал боловсруулсан эсэх	1	1	1 -Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах талаар 2024 онд зохион байгуулагдсан Бичил уурхайчдын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж болон Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо/МБУНДХ/-ноос ирүүлсэн саналыг нэгтгэн, МБУНДХ-ны удирдлагууд болон Бичил уурхайчдын төлөөлөлтэй 3 удаа уулзалт зохион байгуулж, журамд тодорхойгүй байгаа зарим заалтууд дээр санал боловсруулаад байна. -“Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тушаалын төслийг боловсруулаад байна. -Хэнтий аймгийн Бэрх хотод Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас 2025.04.30-ны өдөр зохион байгуулсан “Хэнтий аймгийн бичил уурхайн нөхөрлөлүүдийн уулзалт, хэлэлцүүлэг-2025” арга хэмжээнд АҮЭБЯ-ыг төлөөлөн оролцож, “Бичил уурхайн үйл ажиллагаа, эрхзүйн орчин” сэдвээр мэдээлэл хийсэн.	100
24	9.2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах.	Улсын төсөв	Санал боловсруулсан эсэх	1	1	1 -АҮЭБЯ-ны ХАБЭА-н Салбар хороо, ГБХНХЯ болон Монголын Уул уурхайн Үндэсний ассоциаци хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг 2025.05.15-ны өдөр уул уурхайн салбарын ААН, ХАБЭА-н ажилтнуудын дунд зохион байгуулсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл, зайлшгүй шаардлагуудыг танилцуулан, гарсан саналыг нэгтгэн, хуулийн төслийг эцэслэн боловсруулах Ажлын хэсэгт хүргүүлсэн. -Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.03.24-ны өдрийн А/65 дугаар тушаалаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал,	100

						эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. -Улс орон даяар жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулагддаг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулах тухай удирдамжийг ТНБД бөгөөд салбар хорооны даргаар батлуулан ААН-үүдэд хүргүүлэн, аяны талаарх мэдээлэл, зөвөлгөөг тухай бүрд өгч ажилласан. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян"-ны хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын ХАБЭА-н салбар хорооноос Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоотой хамтран 2025.04.02-05-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Батноров суманд, 16-наас 19-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд суманд, 2025.05.14-19-ний өдрүүдэд Сэлэнгэ, Төв аймгийн Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулан ажиллаж байгаа нөхөрлөлүүдийн дунд ХАБЭА-н хууль тогтоомж сурталчлах, осол аюулаас урьдчилан сэргийлэх онолын сургалтыг танхимаар, осолдогчийг аврах эрэн хайх ажиллагааны дадлага сургуулилтыг олборлолтын үйл ажиллагаа явуулж буй талбайд зохион байгуулсан. - Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор Төрийн ордонд 2025.05.02-ны өдөр зохион байгуулагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулган-III"-нд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга болон гишүүдийн төлөөлөл оролцсон. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчлэн хэлэлцүүлэгт 2 удаа оролцон санал өгч оролцсон. -Стандарт, хэмжилзүйн "Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хороо-08"-д ажиллан 2025.10.27-ны өдөр ГБХНХЯ дээр зохион байгуулагдсан ХАБЭА-н стандартын улсын үзлэгээр дахин хянах шаардлагатай гэж тогтоосон 39 стандартын	
--	--	--	--	--	--	---	--

							төслийг дахин хянаж боловсруулсныг хэлэлцэж, санал өгч ажилласан.	
Зорилго 9. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, эрх зүйн зөвлөгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын мэдээллийн технологийг хөгжүүлэх.								
Зорилт 1. “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.”-ЫН ХҮРЭЭНД								
25	9.1.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж, хуулийн хугцаанд холбогдох газарт хүргүүлэх. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2025 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Арга хэмжээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	-"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны 2020-2025 оны явцын тайланд газартай холбоотой биелэлт гаргасан. -АҮЭБЯ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд газрын үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг төлөвлөж тусгасан. -АҮЭБЯмны 2025 оны төлөвлөгөөтэй уялдуулан Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ТЗУГ-т хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны биелэлтийг гаргасан.	100
26	9.1.2	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг	Улсын төсөв	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	2025 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн газартай холбоотой 1114 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлсэн. 184 бичигт хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.	100

		нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх.						
27	9.1.4	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор гарсан Улсын их хурлын тогтоол, УИХ-ын БХ-ны тогтоол, Засгийн газрын тогтоол, хурлын тэмдэглэлийг харьяа агентлаг, газар /нэгж/-т хүргүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Тухай бүрт нь яаралтай холбогдох газар /нэгж/-т танилцуулсан эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам шинэчлэн батлагдсантай холбоотой сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах тухай АМГТГ-т 2025.01.28-ны 01/239, талбайн мэдээллийг бэлтгэж ирүүлэх тухай ҮГА-нд 2025.03.19-ний 02/825 тоотоор хүргүүлсэн. - Стратегийн ордын хил заагт хамаарагдаж байгаа тухай мэдэгдлийг Оюу толгой, Онтрэ, Эрдэнэс Монгол, Бороо, Цайрт минерал зэрэг ААН-д хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.	100
28	9.1.6	Салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулах, салбарын мэргэжлийн сургалтын байгууллага, их, дээд сургууль, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран мэдлэг, ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах.	Сайдын багцын холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Сургалт зохион байгуулсан эсэх (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А-341 тоот тушаалаар батлагдсан “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг 2.2.9 дахь заалтыг үндэслэн: 1. МГНХЗ-ийн даргын 2025 оны 02/25, 04/25, 05/25, 08/25, 09/25, 10/25, 11/25 дугаар тушаалаар эрх нь дууссан нийт 222 мэргэжилтний хугацааг сунгасан ба АҮЭБЯ-аас албажуулсан гэрчилгээг ЭБМЗ-ийн эрэл, хайлтын программд бүртгэж оруулсан. Үүнд: • Геологийн зураглалын чиглэлээр Зөвлөх: 22 • Геологийн зураглалын чиглэлээр Мэргэшсэн: 24 • Ашигт малтмалын эрэл хайгуулын чиглэлээр Зөвлөх: 65 • Ашигт малтмалын эрэл хайгуулын чиглэлээр Мэргэшсэн: 63 • Өрөмдлөгийн чиглэлээр Мэргэшсэн: 7 • Өрөмдлөгийн чиглэлээр Зөвлөх: 9 • Геофизикийн чиглэлээр Зөвлөх: 13 • Геофизикийн чиглэлээр Мэргэшсэн: 10 • Гидрогеологийн чиглэлээр Мэргэшсэн: 9 Нийт: 222	100

							2. Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс мэргэшсэн инженер, зөвлөх инженер олгох, сунгах батламжийг нийт 190 ирүүлснээс 116 мэргэшсэн инженерийн батламж, 74 зөвлөх инженерийн батламжийг албажуулан хүлээлгэн өгсөн.	
29	9.1.7	АҮЭБСайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг байгуулах, гэрээний биелэлтийн явц, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох газарт хүргүүлэх.	Улсын төсөв	Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн эсэх: (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	Гэрээний төсөлтэй танилцаж санал оруулсан ба АҮЭБ-ын сайд, Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 14 өдөр байгуулж гарын үсэг зурсан.	
Зорилт 2. "Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно."-ЫН ХҮРЭЭНД								
30	9.2.1	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг төлөвлөн, бодлогын газруудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллах.	Улсын төсөв	Зохих газарт хүргүүлэх эсэх (Тийм: 1, Үгүй: 0)	0	1	1. "Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м гэрэлтүүлэг, Сүхбаатар, Асгат сумын бүтээн байгуулалтын барилгын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох тухай тогтоолын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Дугаар:01/1566 /2025.05.20/ 2. Баян-Өлгий аймагт хэрэгжих "Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл" чиглэлийн хатуу хучилттай авто замын 4 дүгээр хэсгийн 23.13 км хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын барилгын ажилд ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох тухай тогтоолын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Дугаар:01/1651 /2025.05.27/ 3. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх 43.3 км хатуу хучилттай авто зам (Өвөрхангай, Хужирт сум)-ын Багц-1 буюу 21.42 км авто замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох тухай тогтоолын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 01/1692 /2025.05.30/	100

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			
1	2	3	4
1	Арга хэмжээ 1. Жонш салбарын татварын орчинг хэлэлцэх төрийн байгууллагуудын уулзалт зохион байгуулах	Төрийн нарийн бичгийн дарга Д.Жавхланбаатар	Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбооны хүсэлтийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр яамны хурлын зааланд Сангийн яам, Татварын ерөнхий газар, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар, Гаалийн ерөнхий газар, Гаалийн төв лаборатори болон жоншны олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцсон хуралдааныг зохион байгуулсан.

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо
1	2	3	4	5
“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
2.1	Арга хэмжээ 2.1 Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн сургалтад хамрагдах6	Сургалтад хамрагдсан байна.	-Батлан хамгаалах яамнаас Олон улсын цэрэг стратегийн нөхцөл байдал, батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэг мэдээлэл өгөх, дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэн үзүүлэх; -“Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ын дагуу дадлага, сургууль, гамшгийн үеийн арга хэмжээ, Газар хөдлөлтийн гамшгийн талаарх Онцгой байдлын газраас хийсэн сургалт. - Уул уурхайн салбарын залуучуудын чуулга уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монголын үндэсний номын санд зохион байгуулсан. - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас зохион байгуулдаг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Уул уурхайн салбарын хуралдаанд 2 удаа танхимаар, 6 удаа цахимаар оролцсон.	2025.01.02 2025.12.05

			- Олборлолтоос боловсруулалт сэдэвт Нүүрс-химийн ахисан түвшний сургалтад 2025 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд хамрагдсан.	
2.2	Арга хэмжээ 2.2 Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад газрын албан хаагчдыг хамруулах, ажлын уян хатан нөхцөлийг бүрдүүлэх. Шалгуур: Тийм-1, Үгүй-0	1	Төрийн худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 2025 оны 02 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд хамрагдсан.	2025.02.24 2025.02.25
2.3	Арга хэмжээ 2.3 Хүний нөөцийн манлайлал, удирдах ур чадвар, хувь хүний хөгжлийн чиглэлээр Монгол бичиг, Англи хэлний сургалтад газрын албан хаагчдыг хамруулах. Шалгуур: Тийм-1, Үгүй-0	1	Хамрагдсан.	2025.01.02 2025.12.05

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
АХЛАХ ШИЖЭЭЧ

.....

/Д.САГАРААДОРЖ/

2025.12.05